

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Аудитор: Ч.Мөнхтогтох  
Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МЭНГЭЭ ТАНАА

2023.02.25 № УВА-2023/13/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0202701377

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red square official stamp of the State Audit Agency of Mongolia is placed over the signature. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГУУГА" (State Audit Agency of Mongolia) and "ТӨСВИЙН АУДИТ" (State Audit). The signature is written in black ink over the stamp.

М.БАТСУУРЬ

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Дүгнэлтийн үндэслэл .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	3
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>113,749,535.00</b>	<b>131,741,108.40</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	11,490,280.00	38,400.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	11,490,280.00	38,400.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	38,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	11,490,280.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	102,259,255.00	131,702,708.40
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	102,259,255.00	123,708,042.40
35410	Бичиг хэргийн материал	1,770,200.00	1,563,850.00
35420	Аж ахуйн материал	25,024,035.00	24,644,035.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,863,400.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	71,601,620.00	97,500,157.40
35600	Мал амьтад	00.00	7,994,666.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,291,379,373.02</b>	<b>1,534,730,598.35</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,291,379,373.02	1,534,730,598.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,254,239,373.02	1,497,740,598.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	422,324,767.00	477,324,767.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-108,117,806.72	-133,929,105.07
39203	Авто-тээврийн хэрэгсэл	290,984,920.00	305,234,920.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-64,695,205.86	-101,351,225.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	163,229,936.00	208,801,362.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113,297,898.88	-114,180,550.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,962,772.00	61,985,808.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,319,160.36	-36,535,934.36
39209	Зам, гүүрийн байгууламж	194,696,506.40	194,696,506.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	590,826,795.50	852,339,122.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-147,412,779.06	-216,701,599.33
39217	Ном	56,527.00	56,527.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	37,140,000.00	36,990,000.00
39301	Програм хангамж	2,020,000.00	2,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,570,000.00	-1,720,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	60,690,000.00	60,690,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-24,000,000.00	-24,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,405,128,908.02</b>	<b>1,666,471,706.75</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,462,180.00</b>	<b>20,276,842.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,462,180.00	20,276,842.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,462,180.00	20,276,842.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	7,462,180.00	20,276,842.00
41361	Байгууллагад төлөх өглөг	7,462,180.00	20,276,842.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,397,666,728.02</b>	<b>1,646,194,864.75</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,397,666,728.02	1,646,194,864.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	327,375,075.15	327,375,075.15
51101	Өмч: - төрийн	327,375,075.15	327,375,075.15
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	752,836,807.14	1,003,705,241.87
51210	Өмнөх үеийн үр дүн	752,836,807.14	755,177,105.14
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	248,528,136.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	317,454,845.73	315,114,547.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,405,128,908.02</b>	<b>1,666,471,706.75</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>336,858,991.00</b>	<b>992,704,950.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>740,000.00</b>	<b>394,230,926.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	740,000.00	394,230,926.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	740,000.00	394,230,926.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	740,000.00	8,256,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	385,974,926.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>336,118,991.00</b>	<b>598,474,024.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,010,591.00</b>	<b>17,070,124.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	401,700.00	3,361,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,608,891.00	3,708,424.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>328,108,400.00</b>	<b>581,403,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,108,400.00	581,403,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>303,634,916.75</b>	<b>744,176,813.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>303,634,916.75</b>	<b>744,176,813.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>258,721,666.75</b>	<b>642,397,591.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>134,408,703.00</b>	<b>289,231,146.00</b>
210101	Үндсэн цалин	111,093,554.00	230,678,483.00
210102	Нэмэгдэл	3,708,207.00	34,878,245.00
210104	Урамшуулал	1,000,000.00	16,837,051.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,606,942.00	6,837,367.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,696,503.00</b>	<b>35,829,681.95</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,516,517.27	24,635,670.48
210202	Тэтгэмжийн даатгал	1,342,487.90	2,834,014.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,073,989.54	2,267,211.64
210204	Ажилгүйдлийн даатгал	251,227.01	549,533.31
210205	Эрүүл мэндийн даатгал	2,512,281.28	5,543,252.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,838,257.00</b>	<b>51,295,148.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,841,257.00	6,690,060.00
210302	Түлш, халаалт	12,997,000.00	44,605,088.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,105,764.00</b>	<b>40,243,214.00</b>
210401	Бичиг хэрэг	1,524,600.00	2,726,210.00
210402	Тээвэр, шатахуун	13,576,300.00	32,452,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,004,864.00	1,915,164.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	922,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	2,226,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>796,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	796,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,008,000.00</b>	<b>19,113,900.00</b>
210604	Урсгал засвар	1,008,000.00	19,113,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,350,000.00</b>	<b>3,069,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,350,000.00	3,069,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,186,739.00</b>	<b>2,644,804.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000.00	474,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	00.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,007.00	136,007.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	377,000.00	465,000.00
210807	Газрын төлбөр	311,732.00	1,067,022.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,127,700.75</b>	<b>200,173,297.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,397,400.00	41,537,462.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	850,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,730,300.75	157,785,835.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,913,250.00</b>	<b>101,779,222.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,913,250.00</b>	<b>60,634,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368,650.00	16,737,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,544,600.00	39,064,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	4,832,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>41,144,922.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	41,144,922.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>33,224,074.25</b>	<b>248,528,136.73</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>33,224,074.25</b>	<b>248,528,136.73</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>336,858,991.00</b>	<b>606,730,024.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>740,000.00</b>	<b>8,256,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	740,000.00	8,256,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	740,000.00	8,256,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	740,000.00	8,256,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>336,118,991.00</b>	<b>598,474,024.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,010,591.00</b>	<b>17,070,124.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	401,700.00	3,361,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,608,891.00	3,708,424.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>328,108,400.00</b>	<b>581,403,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	328,108,400.00	581,403,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>280,033,116.00</b>	<b>586,730,024.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>280,033,116.00</b>	<b>586,730,024.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>235,119,866.00</b>	<b>484,950,801.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>134,408,700.00</b>	<b>288,781,145.00</b>
210101	Үндсэн цалин	108,593,607.00	228,170,843.00
210102	Нэмэгдэл	15,135,441.00	34,741,435.00
210104	Урамшуулал	1,000,000.00	16,387,052.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,679,652.00	9,481,815.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,744,406.00</b>	<b>35,915,982.95</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,547,488.39	24,599,855.12

210202	Тэтгэмжийн даатгал	1,346,719.76	2,871,743.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,077,376.03	2,323,248.95
210204	Ажилгүйдлийн даатгал	252,074.42	532,925.24
210205	Эрүүл мэндийн даатгал	2,520,747.40	5,588,210.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>17,138,257.00</b>	<b>31,245,560.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,841,257.00	6,690,060.00
210302	Түлш, халаалт	13,297,000.00	24,555,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,643,664.00</b>	<b>32,497,064.00</b>
210401	Бичиг хэрэг	1,152,650.00	2,765,650.00
210402	Тээвэр, шатахуун	7,366,150.00	24,413,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,004,864.00	1,915,164.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,306,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	120,000.00	2,096,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>416,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	416,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40,026,500.00</b>	<b>56,843,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,400,000.00	38,350,000.00
210602	Тавилга	00.00	4,950,000.00
210604	Урсгал засвар	3,626,500.00	13,543,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,350,000.00</b>	<b>3,069,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,350,000.00	3,069,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,186,739.00</b>	<b>1,917,550.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000.00	474,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,007.00	136,007.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	377,000.00	465,000.00
210807	Газрын төлбөр	311,732.00	339,768.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,621,600.00</b>	<b>34,263,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,621,600.00	33,413,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	850,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,913,250.00</b>	<b>101,779,222.05</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,913,250.00</b>	<b>60,634,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368,650.00	16,737,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,544,600.00	39,064,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	4,832,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>41,144,922.05</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	41,144,922.05
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>56,825,875.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>20,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>20,000,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	00.00	20,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-20,000,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>56,825,875.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>56,825,875.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /				
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>327,375,075.15</b>	<b>317,454,845.73</b>	<b>752,836,807.14</b>	<b>1,397,666,728.02</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>327,375,075.15</b>	<b>317,454,845.73</b>	<b>752,836,807.14</b>	<b>1,397,666,728.02</b>
<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>327,375,075.15</b>	<b>317,454,845.73</b>	<b>752,836,807.14</b>	<b>1,397,666,728.02</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,340,298.00	2,340,298.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>327,375,075.15</b>	<b>317,454,845.73</b>	<b>755,177,105.14</b>	<b>1,400,007,026.02</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,340,298.00	00.00	-2,340,298.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	248,528,136.73	248,528,136.73
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>327,375,075.15</b>	<b>315,114,547.73</b>	<b>1,003,705,241.87</b>	<b>1,646,194,864.75</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>581,403,900.00</b>	<b>549,027,843.95</b>	<b>32,376,056.05</b>	<b>94.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>561,403,900.00</b>	<b>529,027,843.95</b>	<b>32,376,056.05</b>	<b>94.2</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>500,769,000.00</b>	<b>468,393,543.95</b>	<b>32,375,456.05</b>	<b>93.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>297,087,800.00</b>	<b>286,781,145.00</b>	<b>10,306,655.00</b>	<b>96.5</b>
210101	Үндсэн цалин	271,887,800.00	228,170,843.00	43,716,957.00	83.9
210102	Нэмэгдэл	0.00	34,741,435.00	34,741,435.00	- 0.0
210104	Урамшуулал	0.00	14,387,052.00	14,387,052.00	- 0.0
210105	Гэрээт ажлын хөлс	25,200,000.00	9,481,815.00	15,718,185.00	37.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,136,100.00</b>	<b>35,915,982.95</b>	<b>1,220,117.05</b>	<b>96.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,252,500.00	24,599,855.12	652,644.88	97.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,970,900.00	2,871,743.50	99,156.50	96.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,376,700.00	2,323,248.95	53,451.05	97.8
210204	Ажилгүйдлийн даатгал	594,200.00	532,925.24	61,274.76	89.7
210205	Эрүүл мэндийн даатгал	5,941,800.00	5,588,210.14	353,589.86	94.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,355,600.00</b>	<b>29,050,002.00</b>	<b>305,598.00</b>	<b>99.0</b>

210301	Гэрэл, цахилгаан	5,700,100.00	5,394,502.00	305,598.00	94.6
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,651,800.00</b>	<b>26,685,364.00</b>	2,966,436.00	90.0
210401	Бичиг хэрэг	2,785,300.00	2,765,650.00	19,650.00	99.3
210402	Тээвэр, шатахуун	19,896,900.00	20,152,050.00	-255,150.00	101.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,918,100.00	1,915,164.00	1,002,936.00	65.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500,000.00	1,306,400.00	2,193,600.00	37.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	551,500.00	546,100.00	5,400.00	99.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>55,401,100.00</b>	<b>51,893,500.00</b>	3,507,600.00	93.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,700,000.00	38,350,000.00	350,000.00	99.1
210604	Урсгал засвар	16,701,100.00	13,543,500.00	3,157,600.00	81.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,074,400.00</b>	<b>3,069,900.00</b>	4,500.00	99.9
210702	Дотоод албан томилолт	3,074,400.00	3,069,900.00	4,500.00	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,929,200.00</b>	<b>1,917,550.00</b>	1,011,650.00	65.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,000.00	474,000.00	226,000.00	67.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	288,000.00	12,000.00	96.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	170,775.00	229,225.00	42.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	136,007.00	263,993.00	34.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	44,000.00	156,000.00	22.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	589,200.00	465,000.00	124,200.00	78.9
210807	Газрын төлбөр	340,000.00	339,768.00	232.00	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>45,716,500.00</b>	<b>32,663,600.00</b>	13,052,900.00	71.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,900,000.00	32,113,600.00	12,786,400.00	71.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	816,500.00	550,000.00	266,500.00	67.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>60,634,900.00</b>	<b>60,634,300.00</b>	600.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,634,900.00</b>	<b>60,634,300.00</b>	600.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,833,000.00	4,832,400.00	600.00	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>581,403,900.00</b>	<b>589,659,900.00</b>	-8,256,000.00	101.4
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0.00</b>	<b>8,256,000.00</b>	-8,256,000.00	0.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	8,256,000.00	-8,256,000.00	0.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>16,557,258.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>16,557,258.00</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		16,557,258.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		2,000,000.00
210104	Урамшуулал		2,000,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		2,195,558.00
210301	Гэрэл, цахилгаан		1,295,558.00
210302	Түлш, халаалт		900,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		5,811,700.00
210402	Тээвэр, шатахуун		4,261,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,550,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		4,950,000.00
210602	Тавилга		4,950,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	1600000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		300,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	17070124.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		17,070,124.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,361,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,708,424.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.

- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,400.4 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	11,959.1		-11,959.1
Бараа материал	102,259.2	131,702.7	29,443.5
Үндсэн хөрөнгө	1,291,379.3	1,534,730.5	243,351.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,405,128.9</b>	<b>1,666,471.7</b>	<b>261,342.8</b>

Өр төлбөр	7,462.2	20,276.8	12,814.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,397,666.7	1,646,194.8	248,528.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,405,128.9</b>	<b>1,666,471.7</b>	<b>261,342.8</b>

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 11,959.1 мянган төгрөгөөр буурсан нь арвай буудайн үрийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 131,702.7 мянган төгрөг болж 29,443.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад бараа материал дансанд бүртгэсэн болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нэмэгдсэн материалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,534,730.5 мянган төгрөг болж 243,351.2 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө бүртгэж авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 20,276.8 мянган төгрөг болж 12,814.6 мянган төгрөгөөр өссөн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн заалны барилга ашиглалтад орж халаалтын өр төлбөр үүссэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,666,471.7 мянган төгрөг болж 248,528.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 575,403.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 оны 6 сарын 18-нд Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар төсөвт тодотгол хийж, урьд оны давсан орлогоос 6,000.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 581,403.8 мянган төгрөг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 581,403.9 мянган төгрөгийг баталж өгсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 540,771.8 мянган төгрөг буюу 94.4 хувьтай байгаа нь үндсэн дансны хэмнэгдэл байна. Үндсэн данснаас 40,632.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал / үндсэн үйл ажиллагаа 70106/80101	244,665.3	233,175.6	11,489.6	99.9
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглал /баг хорооны ҮАЗардал 70106/80106 /	118,297.0	115,357.2	2,939.7	97.5

3	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 70106/ 80111 /	45,286.7	42,001.2	3,285.4	92.7
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/нийтлэг үйлчилгээний зардал 70106/ 80112 /	42,620.0	36,883.8	5,736.1	86.5
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ мэдээлэл суртчилгааны зардал 70106/ 80205 /	500.0	300.0	200.0	60.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ ажил олгогчоос олгох тэтгэмж 70106/ 80802 /	43,897.6	43,897.0	0	100
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн зардал 70106/ 80815 /	16,737,300	16,737,300	0	100
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ Бусад зардал 70106/ 80918 /	20,000,000	20,000,000	0	100
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ Орон нутгийн нөөц хөрөнгө 70106/ 81102 /	34,000.0	21,466.8	12,533.1	63.1
10	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ мал тооллого 70106/ 81507 /	1,400,000	1,400,000	0	100
11	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ байгаль орчыг хамгаалах, нөхөн сэргээх 70106/ 81701 /	6,500.0	2,081.2	4,418.7	32.0
12	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ хур хог хаягдал орчны бохирдол 70106/ 82212 /	500.0	471.4	28.6	94.3
13	Орон нутгийн гүйцэтгэх засаглал/ улсын их баяр наадам 70106/ 82801 /	6,000,000	6,000,000	0	100
14	Ахмад настны хөгжил хамгаалал / ахмадын сан / 72208 /81549 /	1,000.000	1,000.000	0	100
<b>ДҮН</b>		<b>581,403.9</b>	<b>540,771.8</b>	<b>40,632.0</b>	<b>94.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,361.7 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,708.4 мянга, хандив тусламжийн орлого 10,000.0 мянга, нийт 17,070.1 мянган төгрөг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин урамшууллын зардалд 1,120.0 мянга, байр ашиглалтын зардалд 2,195.5 мянга, хангамж бараа материалын зардалд 5,811.7 мянга, эд хогшил худалдан авах зардалд 4,950.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,300.0 мянга, нийт 16,557.2 мянган төгрөг зарцуулж байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 512.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 303,634.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 744,176.8 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 7,441.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,953.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын хувьд Төрийн хэмнэлтийн тухай Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дах хэсэгт “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал гаргахыг хориглоно” гэж заасныг зөрчин албан хаагчдад амралт сувилалд амрах зардлыг төсвөөс гаргасан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 149 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 3,500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн биелэлтийг ирүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд “Шинэ хөдөө Увс” төслийн шугамаар ирсэн “Сэлэнгийн халзан-Герефорд” үүлдрийн 7,994.7 мянган төгрөгийн 2 ширхэг өсвөр насны бухыг мал амьтад дансанд бүртгэсэн байна. Тухайн мал амьтныг гэрээ байгуулан иргэдэд эзэмшүүлж байх бөгөөд дараагийн аудитын хүрээнд ашиглалт, гэрээний үр дүнг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар 158,209.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 155,209.7 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 3,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Үнэ төлбөргүй ирсэн 147,215.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад залруулга хийлгэв.
2. Үнэ төлбөргүй ирсэн 7,994.6 мянган төгрөгийн өсвөр насны бухыг мал амьтад данс бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад залруулга хийлгэв.

#### **5.1 Төлбөрийн акт**

Засаг даргын тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 3,000.0 мянган төгрөгийг ажилчдын амралт сувилалд зориулж төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь хэсэгт “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах

тохиолдолд түүний очих, ирэх замын зардал”, гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шинээр нэмэгдсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй	2	155,209.7	2	155,209.7			2	155,209.7				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>155,209.7</b>	<b>2</b>	<b>155,209.7</b>			<b>2</b>	<b>155,209.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Амралт сувилалд зориулж төсвөөс зардал гаргасан	1	3,000.0	1	3,000.0								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,000.0</b>	<b>1</b>	<b>3,000.0</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  М.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр